



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/192

Алтай хот

**Улсын аварга шалгаруулах
цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд
оролцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний ажил үйлчилгээ 1-ийн 1.7 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 онд баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/50 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд баг тамирчдыг оролцуулсугай

2. Тэмцээнд оролцох баг тамирчид, бүрэлдэхүүний нэрийг нэгдүгээр, шаардагдах төсөв хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнд зарцуулагдах 10,037,700 (арван сая гучин долоон мянга долоон зуу) төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Д.Төмөрбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2011 оны
09 дугаар сарын 11-ны өдрийн 149 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧИД,
БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС

Д/д	Овог, нэр	Албан тушаал
1	Хурандаа Д.Төмөрбаатар	Цэргийн штабын дарга
2	Дэд хурандаа Г.Баасанцог	Тоо бүртгэлийн офицер
3	Ахмад Г.Мөнхбаяр	Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер
4	Ч.Хашвай	Биеийн тамирын багш
5	Э.Мөнхтөгөлдөр	Сурагч
6	Б.Эрдэнэбаяр	Сурагч
7	Г.Соронзонболд	Сурагч
8	Д.Буд-Эрдэнэ	Сурагч
9	Э.Хишигдорж	Сурагч
10	Ц.Цэрэндаш	Сурагч
11	А.Баяржавхлан	Сурагч
12	Б.Нинжин	Сурагч
13	Ц.Болор-Эрдэнэ	Сурагч
14	М.Алтжин	Сурагч
15	Б.Азжаргал	Сурагч
16	М.Энхсүлд	Сурагч
17	Б.Чойжин	Сурагч

Аймгийн Засаг даргын 2011 оны
 08 дугаар сарын 11-ны өдрийн 44 дугаар
 захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Тоо, ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Аймгийн далбаа (2x1)	3x180000	180000	540000
2	Photostandсамбар (1.8x0.8)	1x120000	120000	120000
3	Энгэрийн таних тэмдэг	13x15000	15000	195000
4	Биеийн тамирын хувцас	13ш	150000	1950000
5	гутал	13ш	77000	1001000
6	Улаанбаатар хотруу явах шатахууны зардал (2 тээврийн хэрэгсэл)	2400x20 480л x 2850т	1368000	1368000
		2400x20 480л x 4190т	2011200	2011200
7	Алтай сумаас аймагт ирж очих шатахууны зардал	750x20 150л x 2850т	427500	427500
8	Хоолны зардал (өдрийн 3 хоол)	25000x13x5	-	1625000
9	Тоогоочийн цалин	5x100000	500000	500000
10	Бусад зардал	-	300000	300000
Нийт				10037700